



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/45

Батширээт сум

Сумын Засаг даргын  
2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг  
хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 03 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, жил бүр тайлагнахыг сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Бүдханд)-д, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Төрмөнх)-д тус тус даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

БАЛТАНГЭРЭЛ

232501090